

МОНГОЛЫН УЛС ТӨРИЙН СЭТГЭЛГЭЭНИЙ ЭХ СУРВАЛЖ

Л. Идэр

Доктор (Ph. D.)

*Шинжлэх ухаан, технологийн их сургууль
Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль
ider@must.edu.mn*

Хураангуй: XIII зууны үеийн нийгэм-улс төрийн сэтгэлгээ, Монголын түүх, улс төрийн сэтгэлгээнд чухал байр суурийн эзэлдэг. Монголын төрт ёсны түүхэн уламжлалыг хадгалсан түүх архивын баримт бичигт орсон зүйл, бусад мэдээллээс эхлээд эрдэмтэн, мэргэд түүхч нарын тэмдэглэл, “Арван буянт номын цагаан түүх” зэрэг олон арван материал нь Монголын төрт ёсны түүхэн уламжлал, улс төрийн сэтгэлгээний түүхийг судлахад чухал ач холбогдолтой юм. Их Монгол Улсын улс төрийн сэтгэлгээ нь өмнөх үеийн төрт ёсны уламжлалд суурилж, түүхэн цаг үеийн өөрчлөгдсөн орчин нөхцөл, Монголчуудын бодит ахуй, амьдралын хэв маяг, хэвшил, нутаг дэвсгэрийн хэмжээгээр нөхцөлдсөн үндэстний сэтгэл зүй, зан араншин, итгэл бишрэл, захирах, захирагдах ёсонд хандах хандлага, тэдний үзэл, бодлого, ‘үнэлэмжийн өвөрмөц тусгал болж байлаа. Энэ үеийн улс төрийн сэтгэлгээний бүрдэлт, төлөвшилт нь тухайн түүхэн тодорхой цаг үеийн бодит хүчин зүйлүүдээр нөхцөлдсөн үзэл санаа, танин мэдэхүй, гүн ухааны гүнзгий үндэс улбаатай үйл явц байсан юм.

Түлхүүр үгс: Улс төрийн сэтгэлгээний түүх, төрт ёс, уламжлал, ёс зүй

I. УДИРТГАЛ ХЭСЭГ

Энэ удаагийн судалгааны гол судлагдахуун болох Их Монгол улсын үеийн улс төрийн сэтгэлгээний эх сурвалж, шинж, онцлогийн асуудалтай холбогдон гарч ирж болох олон чухал асуудалд хариу нотолгоонд онол, арга зүйн талаасаа үлэмжхэн ач холбогдолтой юм.

Хэдийгээр Монголчуудын улс төр сэтгэлгээний үүсэл бүрдэлтийн үйл явц нь хичнээн ч үндэстний онцлог, зүй тогтлын дагуу хэрэгжсэн байлаа ч сэтгэлгээний үүсэл, төлөвшилтийн нийтлэг зүй тогтолоос хол хөндий байж чадаагүй, харин ч түүний өвөрмөц тусгал байсан нь ойлгомжтой. Тиймээс энэ удаагийн судалгааны явцад Монголчуудын улс төр сэтгэлгээний үүсэл бүрдэлтийн өвөрмөц зүй тогтол, харилцан хамаарлын асуудал шинжлэх ухааны судлагдахууны талаасаа сонирхол татахуйц юм. Аливаа үзэгдэл, үйл явцын нийтлэг жишиг, зүй тогтол ямагт өвөрмөц, тусгал зүй тогтлоор дамжин илэрдэг жамтай тул энэ удаад эл асуудлыг тодотгон авч үзэх үүднээс Монголчуудын улс төрийн сэтгэлгээний үүсэл бүрдэлт, хөгжлийн зүй тогтлын асуудлыг хөндөж байгаа болно.

II. ОНОЛ, АРГА ЗҮЙН ХЭСЭГ

Монголчуудын улс төрийн үзэл, сэтгэлгээний түүхийг бүтээгч нь Монголын ард түмэн өөрсдөө юм. Тэд Монголын нийгэм дэх олон зууны туршид үргэлжилсэн улс төрийн үзэгдэл, үйл явцыг ажиглан харж, тэр үндсэн дээр өөрсдийнхөөрөө үнэлэн цэгнэж, тусган ухаарч байсны тодорхой илрэл, үр дүнд тэдний улс төрийн сэтгэлгээ үүсэн бүрэлдсэн байна. Монголчуудын улс төрийн сэтгэлгээний оюун санааны суурь үндэс нь тэдний улс төрийн ухамсар мөн бөгөөд энэ нь тэдний нийгмийн ухамсрын онцгой нэгэн хэлбэр болж байжээ. Монголын ард түмний оюунлаг үйл ажиллагаа, нийгмийн ухамсар нь үүсэл, хөгжлийн төвөгтэй, урт замналыг туулжээ. Энэ нь нийгмийн ухамсар, улс төрийн сэтгэлгээний хөгжлийн үйл явцын тодорхой тусгал болж байлаа.

Монголчуудын төрт ёсны уламжлал Хүннү гүрнээс эхтэй бөгөөд цаашид төрт ёсны уламжлалаа хадгалан тогтвортой явуулж ирсэн байдаг. Иргэншлийн төлөв байдал нь хүн төрөлхтний эдийн засаг, аж ахуй болон хүмүүсийн хамтын амьдрал, тэдний хоорондын харилцаа, оюун санаа, ухамсрын хүрэн дэх асар их дэвшил өөрчлөлтийг өөртөө багтаадаг. Тэр дундаа иргэншлийн төлөв байдлын хүрээнд илэрсэн нийгэм-улс төрийн томоохон өөрчлөлт нь нийгмийн анги, давхарга, бүлэг бий болж, тэдгээрийн өвөрмөц ялгаа бүхий эрх ашиг, сонирхол ялгаран гарч, түүнийг зохицуулах үүрэг бүхий улс төрийн хамтын зохион байгуулалтын хэлбэр болсон төр бүрэлдэн бий болсон явдал юм.

Эртний төрт улсын үед улс төрийн зохион байгуулалт, эрх мэдэл, засаглал, удирдлага, үнэлэмж баримжааллын анхны тодорхой хэлбэр, элементүүд бий болж байжээ. Нэг үгээр хэлбэл, төрийн үед улс төрийн түүхэн үзэгдэл, үйл явцын тусгал, илэрхийлэл болж хүн төрөлхтний анхны ердийн ухамсарын түвшин дэх улс төрийн үзэл, төсөөлөл, мэдлэг, ухамсарыг агуулсан улс төрийн сэтгэлгээ үүсэн бүрэлдсэн байна. Энэ үеийн улс төрийн сэтгэлгээ нь ёс зүйн уламжлалыг чухалчилсан шинжтэй байдаг нь түүхэн баримтуудаас илэрхий байдаг. Энэ бүхнээс дүгнэж үзвэл улс төрийн сэтгэлгээ үүсэн тэрлэх анхдагч бодит нөхцөл, үндэс нь нийгэмд анги, бүлгүүд үүсч, тэдгээрийн өвөрмөц эрх ашиг, сонирхол бий болж, ялгарал, зааг нь гүнзгийрч, түүнээс үүдсэн хоорондын зөрчил, асуудлыг зохицуулах үүрэг бүхий хүмүүсийн улс төрийн зохион байгуулалтын хэлбэр болсон төр үүссэн явдал юм. Энэ нь тухайн үеийн тэмцэл, хааны ширээ залгамжлах үйл явцаар илэрч байна.

Монголын түүхэнд дурдсанаар МЭӨ III зуунд Төв Азид анхны томоохон төр улс болох Хүннү гүрэн байгуулагдан, улс төрийн ахуй, түүний үндсэн шинж тэмдэг, үзэгдэл, үйл явдлууд тэр үеийн боломжит хэлбэр хэмжээгээр бүрэлдэн явагдаж байжээ.

Аливаа ард түмний улс төрийн сэтгэлгээний түүхийг судалж танин мэдэхэд түүний агуулга дахь бодит, үнэн мэдлэг ба үзэл суртлын үнэлгээ, дүгнэлт, санаа бодлын ялгаа хийгээд холбоо хамаарлыг нягтлан гаргах явдал чухал болно. Улс төрийн сэтгэлгээний түүх бол улс төрийн ахуй амьдрал, түүхэн үйл явдлыг танин мэдсэний үр дүн бүхий дан улс төрийн бодит мэдлэгийн сан хөмрөг, эсвэл улс төрийн амьдрал, түүхэн үйл явдлуудыг нийгмийн аль нэгэн анги бүлгийн эрх ашиг, зорилгын үүднээс тусган илэрхийлсэн дан үзэл суртлын санаа бодол ч биш, харин тэдгээрийн аль алиныг нь түүхэн тодорхой байдлаар хослуулж агуулсан байдаг. Гиймээс түүхийн аль нэгэн үеийн улс төрийн сэтгэлгээний түүх ба тэр нь тусаж тэмдэглэгдсэн сурвалж бичиг, бусад баримт сэлтийг түүхэн тодорхой байдлаар хандаж задлан шинжлэх, тэдгээрийн агуулга дахь улс төрийн мэдлэг ба үзэл суртлын элементийг ялган гаргаж тавих хэрэгтэй юм.

Монголын улс төрийн сэтгэлгээний түүхийг судлахдаа асуудалд хандахдаа нэрт эрдэмтэн Ч.Жүгдэрийн цуврал бүтээлүүдээс судалгааны арга зүй суурь дэвсгэр болгож авч үзсэн. Монголын улс төрийн сэтгэлгээний асуудлыг Ч.Жүгдэр, Феодализм тогтох үеийн Монголын гүн ухаан, нийгэм улс төрийн сэтгэлгээ (Эртнээс XIV зуун) УБ., 1987 он, Ч.Жүгдэр, XV-XVIII зууны нийгэм- улс төр, гүн ухааны сэтгэлгээний хөгжлийн түүхэн тойм УБ., 1984 он, Ч.Жүгдэр, XIX-XX зууны зааг дахь Монголын нийгэм- улс төр, философи сэтгэлгээний хөгжил УБ., 1972 он зэрэг бүтээлүүд нийгэм улс төрийн сэтгэлгээний үечлэл агуулга арга зүйн талаас авч үзсэн бол, Монголын философийн түүх, I дэвтэр, УБ., 1997 он, Монголын философийн түүх, (XIII-XVIII) II дэвтэр, УБ., 2000 он бүтээлүүдэд улс төрийн сэтгэлгээний түүхийн судалгаа, түүх бичигдсэн хугацаа, зохиогч, агуулгыг авч үзжээ. Монголын төрийн байгуулал, улс төрийн сэтгэлгээний хөгжил (мэ III- мэ XX зуун) I, II боть УБ., 1995 он бүтээлд улс төрийн түүх, төрт ёс талаар дурдсан байна. Тэдгээр нь Монголын улс төрийн сэтгэлгээний талаар түүхэн үзэгдлийг судалж танин мэдэх, онолын үүднээс нэгтгэн дүгнэхэд жинтэй хувь нэмэр болж байна. Монголын улс төрийн сэтгэлгээний түүхийг судлахад Монголын эртний эх сурвалжаас гадна Монголын түүх уран зохиолын дурсгал бичиг, эрдэмтдийн олон арван бүтээл байгаа нь зүй ёсоор авч үзэж дурдах ёстой билээ.

Г.Сүхбаатар, Ц.Доржсүрэн, Х.Пэрлээ, Ш.Нацагдорж, Н.Ишжамц, Ш.Бира, Д.Гонгор, Дандаа хэмээх Дэмчигдорж, А.Майдар, Ч.Далай нар түүх, төрт ёсны уламжлал, түүхэн талаас авч үзсэн бол В.Инжинаши, Лувсанданзан, Саганцэцэн, заваа Дамдин, Д.Равжаа, Рашипунцаг, Б.Ринчен, Ц.Дамдинсүрэн, Д.Цэрэнсодном нар утга агуулга, хэл шинжлэлийн үүднээс тайлбар тодотгол, харьцуулалт хийжээ. Мөн философи, улс төр судлаач эрдэмтэн Б.Болд-

Эрдэнэ, Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан, А.Цанжид, Ц.Ганболд, А.Юндэндорж, С.Базарпүрэв, Г.Цэнд-Аюуш, Ж.Төртогтох, Ц.Батболд нарын зэрэг эрдэмтэд төр ёсны уламжлал, шинэчлэлийг орчин үеийн улс төрийн шинжлэх ухааны талаас судалсан төдийгүй дээрх судлаачид, эрдэмтэд Монголын улс төрийн сэтгэлгээний түүхийн талаар нилээдгүй чухал мэдээ, тайлбар, дүгнэлт санал дэвшүүлжээ.

Гадаадын олон эрдэмтэд Монголын төрт ёсны түүхэн уламжлал, улс төрийн түүхийн эх сурвалжийг анхааран судалсан байна.Тухайлбал түүхч Марко Поло, Жувейни, Пано Карпини нар өөрсдийн зохиол бүтээлдээ: Монголын төрт ёсны түүхэн уламжлалын тухай түүхчлэн бичсэн бол Макриз, Рашид-Ад-Дин нар Монголын төр ёсны дурсгалыг авч үзжээ. Эдгээр түүхч эрдэмтдийн зохиол бүтээлд үндэслэн Монголын төрт ёсны талаар эрдэмтэн Б.Я.Владимирцов, Л.Л.Викторова, А.Б.Рязановский, Л.Н.Гумилев, Л.И.Думан, К.Ф.Голстунский, Сайшаал, И.С.Урбанаева, Х.Футаки нар түүх, төр ёсны талаар авч үзэж судалсан байна. Тэдгээрт хууль дээдлэх ёс, төрийн эрх мэдэл хуваарилах, улс төр, төрт ёсны уламжлал, шинэчлэлийн талаар тодорхой асуудал дэвшүүлсэн байна. Гэвч Монголын төрт ёсны түүхэн уламжлалыг авч үзсэн хэдий ч улс төрийн сэтгэлгээний түүхийн чиглэлээр судалж бичсэн бүтээл хангалтгүй байна. Эл судалгаа нь Монголын төрт ёсны түүхэн уламжлал, улс төрийн сэтгэлгээний түүхийн үүднээс авч үзэж онцлогийг гаргаж нэгтгэн дүгнээд энэ чиглэлийн судалгааг цаашид өргөжүүлэх онол, практикийн чухал ач холбогдолтой юм.

Монголын төрт ёсны уламжлалын гол эх сурвалжууд гэвэл “Монголын нууц товчоо”, “Лу Алтан товч”, “Судрын чуулган”, Чингис хааны “Их засаг”, “Түмэдийн Алтан хааны цааз”, Халх Ойрадын “Дөчин дөрвөн хоёрын их цааз”, Халх журам, 1570 оны Мандухай цэцэн хатны “Ойрадын тухай цааз”, 1570 оны Түмэдийн Алтан хаан Анандын (1507-1582) “Шашин төрийн цааз”, 1558-1593 онд төр барьсан Түмэн засагт хааны “Засаг цааз” түүнчлэн “Арван буянт номын цагаан түүх” нь Монголын төр ёсны уламжлал, улс төрийн сэтгэлгээний асуудлыг тодорхой хэмжээгээр тусгагджээ. Эдгээрийн тухай “Эрдэнийн товч”, “Алтан товч”, “Шар товч” зэрэг сурвалж бичигт дурджээ.

XIII-XIV зууны Монголчуудын улс төрийн сэтгэлгээний түүхэн хөгжлийг тодорхойлохын тулд ардын аман зохиол, түүхэн холбогдолтой сурвалж бичиг хэрэглэгдэхүүн болоод тэдгээрийг судалсан манай болон гадаадын эрдэмтэн судлаач, түүхчид, философичдын судалгааны зохиол бүтээлээс нягтлан үзвэл хамгийн үнэтэй, тулгуур бүтээл нь “Арван буянт номын цагаан түүх” болон бусад эх сурвалж түүний судалгаа гарцаагүй мөн.

Монголчуудын төрт ёсны сэтгэлгээ МЭӨ III зуунаас МЭ XVII зууны үеийг хүртэл хааны зарлиг, билиг сургаал, номлол зэргийг нэг эх сурвалжид

багтаан оруулсан байдгаараа онцлог. Эдгээр шинжүүд нь “Монголын нууц товчоо”, “Алтан товч”, “Арван буянт номын цагаан түүх”, “Оюунтүлхүүр”, Инжинашийн “Хөх судар” зэрэг түүх, хэл, уран зохиолын эх сурвалжуудад илүү тодорхой харагдана. “Арван буянт номын цагаан түүх” төрт ёс, улс төрийн сэтгэлгээний үнэтэй эх сурвалжийн нэг юм.

Орчин үед улс төрийн сэтгэлгээний түүхийн судлах зүйлийг төрийн тогтолцооны үүсэл, хэв маяг, нийгмийн бүлэглэлүүдийн зөрчил тэмцэл, ялангуяа түүний төвлөрсөн илрэл улс төрийн намуудын төлөвшил, байр суурь, улс төрийн харилцаа, үйл явцын өрнөл хөгжлийн түүх хэмээн үзэж байна.

Хүний нийгэм өөрийгөө ухамсарлах, танин мэдэх нь түүний хэвийн оршин тогтнол, хөгжил дэвшлийн чухал хүчин зүйл болдог. Тухайн нийгэм, ард түмэн өөрийнхөө туулж өнгөрүүлсэн түүхийг эргэн харж санах, судалж танин мэдэх, түүний туршлага, алдаа онооноос сургамж авах замаар түүхийн ухамсартай болдог, тэр дотор улс төрийн түүхээ ухамсарладаг байна. Монголын ард түмэн аж ахуй, эдийн засаг, нийгмийн болон улс төрийн байгуулал, гадаад харилцаа, соёл, иргэншил, шашин, оюун санааны амьдралын түүхийг агуулсан бөгөөд цогц, өнө эртнээс улбаатай эх түүх, улс төрийн сэтгэлгээний баялаг түүхтэй билээ.

Монголчуудын гол онцлог бол ам дамжуулан үлгэр домгоор түүхээ хадгалан үлдсэн байдаг.

Энэ нь Монголын улс төрийн сэтгэлгээний түүх нэн эртний үед холбогдож байгааг илэрхийлж байна. Түүний үр дүнд нийгэм, улс төрийн амьдралын тухай тэр үеийн хүмүүсийн ойлголт, үзэл санааны агуулга, тойм зураглал ерөнхий байдлаар гарсан байна. Тухайлбал, эзэн хаан, түүний засаглалын гарал үүсэл захирах захирагдах харилцаа, хүчирхийлэл, албадлагыг үзэх үзэл зарим талаар тодорхой болсоор байна. Тэр үед эзэн хаан бол тэнгэрийн хөвгүүн бөгөөд түүний эрх мэдэл, засаглал тэнгэр гаралтай гэх мэт үзэл байсан байна. Гэвч Монголын улс төрийн сэтгэлгээний түүхийн агуулга, голлох үзэл санаа, хөгжлийн түвшин ямар байсан нь одоогоор төдийлөн тодорхой бус байгаа бөгөөд учир нь тэдгээрийг илэрхийлэх, батлан нотлох түүхэн баримт, дурсгалт бичиг ховор байна. Тийм учраас эртний үеийн Монголын улс төрийн сэтгэлгээний түүхэн тоймыг гаргахыг оролдохдоо одоогоор тодорхой болж ашиглаж буй сурвалж бичиг, улс төрийн сэтгэлгээний түүхэнд шууд болон дам байдлаар холбоо хамааралтай, янз бүрийн эх сурвалжаас олдож буй мэдээ, баримтыг анхааралтай авч үзэж, тэдгээрийн утга санааны логик холбоо, нэгдлийг гаргах, ерөнхий агуулга, утга санааг нь реконструкцийн аргаар бүхэлд нь сэргээн гаргаж тавих, байж болох шинэ сурвалж бичгүүд, бусад баримт сэлтийг эрж хайх нь судалгааны шинжлэх ухаанч зарчимд нийцэх одоогийн хамгийн боломжит, бодит зорилт юм.

Монголын улс төрийн сэтгэлгээний түүхийн ул мөр нилээд балархай байгаатай холбогдон, энэ асуудлыг авч үзэх явцад олон янзын асуулт, бэрхшээл гарч байна. Тухайлбал, ер нь энэ үед Монголчуудын улс төрийн түүхэн үйл явц ямар түвшинд байсан, тухайн үеийн хэмжээсээр зохих түвшинд хүрсэн, нийгмийн синкрет чанартай сэтгэлгээнээс бие даан ялгаран гарч байсан уу, түүний ул мөр яагаад балархай байна вэ, холбогдох дурсгалт бичиг, аман болон бусад мэдээ сэлт яагаад ховор байна вэ, эсвэл дурдан буй үед Монголчууд нийгэм- улс төрийн сэтгэлгээ төдийлөн ялгарч бие даан гарч ирээгүй, улс төрийн ахуйг зохих хэмжээгээр ухамсарлах түвшинд хүрээгүй байсан уу, аль эсвэл энэ үетэй холбоотой дурсгалт бичиг, эх сурвалжууд байгаа ч гэсэн бид тэдгээрийг олж тогтоогоогүй байна уу гэх зэрэг хариу тайлбар, баталгаа нотолгоо шаардсан, гипотетик асуултууд урган гарч тавигдаж байгаа юм. Эдгээр асуултанд чухамдаа ул суурьтай судалгааны үндсэн дээр зохих хариу тайлбар өгөх зэргээр асуудалд хандах нь чухал юм.

III. СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Судлаачдын бүтээлүүдээс үзэхэд Монголын улс төрийн сэтгэлгээний түүх бол нэг талаас Монголын нийгэм, түүний улс төрийн ахуй амьдралын түүхэн замнал нь Монголчуудын улс төрийн мэдлэг ухаанд туссан мэдлэгийн сан, дүр зураг, нөгөө талаар түүхэн янз бүрийн үеийн Монголын нийгэм, улс төрийн амьдралын өөрчлөлт, хөгжлийн хандлага, хэрэгцээ шаардлага, түүнчлэн нийгмийн тэргүүлэгч, ноёрхогч анги давхраа, улс төрийн хүчнүүдийн эрх ашиг, байр суурь, зорилгын үзэл суртлын илэрхийлэл болох нь харагддаг юм.

Улс төрийн сэтгэлгээний түүх түүний тодорхой илэрхийлэл, хэлбэрүүд нь (улс төрийн үзэл санаа, сургаал, онол, номлол, үзэл суртал) түүхэнд амьд тодорхой сэтгэгчид, онолчдын амьд сэтгэлгээний хэлбэрээр гарч ирж хөгждөг жамтай. Гэтэл тэдгээр сэтгэгч, амьд сэтгэлгээ мөнх бус бөгөөд эцэс төгсгөл нь ирэхлээр мөхдөг зүй тогтолтой билээ.

Түүхэнд үүсэн боловсрогдож, тодорхой хугацаанд оршиж байсан улс төрийн үзэл санаа, сургаал, онол, номлолын тэмдэглэгдэх, хадгалагдан уламжлагдах гол хэлбэр, төрөл зүйл нь ихэвчлэн бичиг номын хүмүүс, философичид, улс төрийн сэтгэгчид, үзэл сурталчид, шашин, нийгэм, улс төрийн зүтгэлтэн, соён гэгээрүүлэгчид, яруу найрагч, зохиолчдын бичиж туурвисан ном зохиол, түүх шастир, утга зохиолын дурсгалт бичиг, төрийн хууль, хаад ноёдын зарлиг болон бусад баримт бичиг, улс төрийн нам, олон нийтийн байгууллагуудын мөрийн хөтөлбөр, тунхаглал зэрэг албан ёсны баримт бичгүүд байсаар иржээ. Эртний үеийн ард түмнүүдийн улс төрийн сэтгэлгээ, үзэл санааны зарим ул мөр, үлдэц хаадын орд харш, булш бунхан,

хөшөө дурсгалд сийлсэн бичээс, түүнчлэн мал амьтны далны яс, шавар, мод, зэс самбар, далдуу модны навчис, хус модны үйсэнд бичигдэн үлдсэн нь цөөнгүй юм. Гэвч тэдгээрийн утга санаа, агуулга нь ихэнх нь бүрэн бүтэн бус, хэсэгчилсэн байдалтай байдаг ажээ.

Улс төрийн сэтгэлгээ бол Монголын ард түмний нийгмийн сэтгэлгээний түүхэнд томоохон байр суурь эзэлж, түүний тэргүүлэх чиглэлийн нэг болсоор ирсэн баялаг агуулгатай, үндэсний онцлог шинжтэй, анхаарал татсан түүхийн үнэт өв сан болох нь эдүгээ шинжлэх ухаанд нэгэнт тодорхой болсон зүйл юм. Тиймээс түүнийг судлах, шинжлэх ухааны эргэлтэнд оруулах нь чухал болсоор байна.

Улс төрийн сэтгэгчид, төрийн зүтгэлтэн, нийтлэлчдийн туурвилд улс төрийн сэтгэлгээ тусгалаа олж бүтээгдсэн байдаг. Аливаа улс төрийн номлол хийсвэр сэтгэлгээний ямар нэгэн түвшинд, цаг үеийнхээ аль нэг нийгмийн бүлэг, ангийн сонирхлыг хөндөж тухайн төр улс, улс төрийн амьдралыг илэрхийлдэг.

Улс төрийн сургаал, номлол тодорхой судлаач эрдэмтний бүтээл ч түүний ач холбогдол нийгмийн шинж чанартай төдийгүй мөн нийгмийн өмнө хариуцлага хүлээсэн байдаг. Нийгмийн ямар нэгэн бүлэг үзэл суртлын хувьд өөрийгөө тодорхойлох, ухамсарлахад улс төрийн номлол үлэмж чухал үүрэгтэй ажээ. Үзэл суртал төлөвшсөн цагт олон түмний улс төрийн ухамсарт нөлөөлөөд зогсохгүй мөн төрийн бодлого шийдвэрт тусгагддаг байна. Тэгэхлээр зөв уриа лоозон, үзэл суртал байх ёстой нь дамжиггүй харин туйлширч болохгүй гэдгийг цагаан түүхэнд дурдсан байдаг. Улс төрийн сэтгэлгээ нь бодит түүхийн явцад бий болж шалгарлаар улам биежин батжиж байдаг.

Улс төрийн сургаал нийгмийн дийлэнх олонхын анхаарлыг татсан, ихэвчлэн үл гүйцэлдэх, туйлын сайн сайхныг бүрдүүлэхэд баримжаалагдан бүтээгдсэн байдаг онцлогтой [1]. Улс төрийн сургаалын түүх бол хүн төрөлхтөний нийгмийн сэтгэлгээний хөгжлийн салшгүй чухал хэсэг мөн.

Улс төрийн сэтгэлгээний түүх нь тухайн үеийн ард түмэн, түүний дотроос төрж гарсан сэтгэгчдийн зүгээс улс төрийн бодлого, төр засаглал, нийгмийн анги, бүлгүүдийн эрх ашиг, эрх, эрх чөлөө, шударга ёс, ардчилал, дарангуйлал, хууль цааз, улс орнуудын хоорондын харилцаа, дайн ба энх зэрэг улс төрийн үзэгдлүүдийг ухааран ойлгох, танин мэдэх талаар гаргасан оролдлого, чармайлтын үр дүн болж бүрэлдэж боловсрогдсон мэдлэг, үзэл санаа, сургаал номлолыг өөрөө агуулна[2]. Хожим хойч үеийнхэн өөртөө тулгарсан улс төрийн онол, танин мэдэхүйн болон практикийн шинэ асуудал зорилтыг шийдвэрлэх оролдлого хийхдээ өнгөрсөн үеийн улс төрийн сэтгэлгээний түүх рүү эргэн харж түүнээс ухаарал олж, сургамж авдаг. Энэ

талаар манай оронд баялаг бөгөөд чухал туршлага хуримтлагджээ. Бид энэ баялаг туршлагаас суралцах шаардлагатай байна. Улс төрийг ойлгож танин мэдэх үйл явц, улс төрийн үзэл баримтлал, номлолыг задлан шинжилж судлахад улс төр, улс төрийн сэтгэлгээний түүхийн мэдлэг зайлшгүй чухал болохыг улс төрийн шинжлэх ухааны хөгжлийн үйл явц бэлхнээ харуулсан болно.

Хүн төрөлхтөн хүрээлэн буй бодит байдлыг танин мэдэж, түүнийг ашиглаж сурах гэсэн хүсэл тэмүүллийн нэг чиглэл болсон нийгмийн шударга байгууллын тухай эргэцүүлүүд нэн эртний үед үүссэн билээ. Хүн бий болж хамтын амьдралаар амьдрах болсноор янз бүрийн бүлэглэлүүд үүсэн улам боловсронгуй болсоор ирсэн байдаг. Өдгөө хүртэл шилдэг төрийн механизм бүрдээгүй нь нийгэм, улс төрийн хөгжил хэрэгцээгээр тайлбарлагдана.

Анхны танин мэдэхүйн эргэцүүлүүд мөн чанартаа улс төрийн үзэл санаа гэхээсээ өв уламжлал, ёс заншил, хуулийг дээдлэн хүндэтгэхийг чухалчлан сургамжилсан шинжтэй байв [3].

Улс төрийн үзэл санаа нь шашин, философи хийгээд ёс суртахуунаас салж бие даасан салбар болон оновчтой хэлбэрийг олох хүртэл олон зууныг өнгөрөөсөн юм.

Улс төрийн шинжлэх ухааны бүрэлдэн тогтох үйл явц, түүний мөн чанар, хэлбэрших механизм, өмнөх үеийнхний их сэтгэгчдийн дэвшүүлж байсан онол, үзэл баримтлалууд, тэдгээрийн судалгааны арга зүйн талаар хуримтлуулсан ололт амжилтанд түшиглэсэн залгамж чанарыг агуулж ирсэн байдаг.

Дэлхийн улс төрийн сэтгэлгээний түүхийн судалгааны практикаас үзвэл дээрх сурвалж бичгүүдийн ихэнхийг улс төрийн сургаалын үндсэн сурвалж материал болгон ашигладаг байна.

Харин уран зохиол, тухайлбал, ардын аман зохиолыг улс төрийн сэтгэлгээний түүхийн сурвалж бичиг болгон ашиглах талаар өрнө ба дорнын орнууд, тэр дотор Монголын хувьд өвөрмөц онцлог, ялгаатай зүйл багагүй бий. Монголчууд, ер нь нүүдэлчин малчин ард түмнүүдийн ертөнцийг үзэх үзэл, эрхэмлэл, гүн ухаан, нийгэм-улс төр, ёс зүй, гоо зүйн сэтгэлгээ, үзэл санаа нь уран үг, уран дүр, дүрслэлээр, ардын аман зохиолоор илэрхийлэгдэж, хадгалагдан уламжлагдаж иржээ. Тиймээс түүхийн үед Монголын ард түмний бүтээсэн аман зохиол түүний янз бүрийн төрөл зүйлийг улс төрийн сэтгэлгээний түүхийн аспектээр тусгайлан судлах, тэдгээрийн улс төрийн үзэл санаа, утга агуулгыг шүүрдэн гаргаж нэгтгэн дүгнэх шаардлагатай юм.

Тухайлбал, Монголын төр, нийгмийн зүтгэлтэн, түүхэн бие хүмүүс, баатар, сайн эрс, нийгэм-түүхийн томоохон үйл явдлын тухай домог, хууч

ярианд ард олон, энгийн хүн ардын эрх, эрх чөлөө, шударга ёс, тэгш байдлыг үзэх үзэл санаа, эрхэмлэл, чин хүслэн, мөрөөдөл нь тусгагдсан байдаг.

Монголчуудын улс төрийн үзэл санаа, улс төрийн эрхэмлэл нь ардын зүйр цэцэн үгэнд ч тусгагдан онч мэргэн, уран, нэгтгэн дүгнэсэн товч хураангуй байдлаар илэрхийлэгдсэн байдаг. Энэ бол өвөрмөц, хосгүй үзэгдэл бөгөөд учир нь нийгэм, төр, улс төр, эх орон, эрх чөлөө, шударга ёс, тэгш байдал, дарлал мөлжлөг, бурангуй ёсыг үзэх үзлээ тийнхүү зүйр цэцэн үгэндээ тусган илэрхийлдэг ард түмэн билээ.

Монголчууд: “Төр гэдэг төмөр нүүртэй, төрсөн бие махан нүүртэй”, “Төр ёс түвшин бол, төрийн эзэн мэргэн”, “төрийн ёсыг сахиж явбал, түмэн олондоо нэртэй болдог, төв журмыг дагаж явбал, түмэн зүйлийг мэдэж болдог”, “Төр төмбөгөр, ёс ёмбогор”, “Төр түвшин бол, түмэн олон амгалан”, “Төр түмэн нүдтэй, төрсөн бие хоёр нүдтэй”, “Төр цаазанд баригдах, төмөр хадаасанд баригдах”, “Төрд нэргүй, түмэнд цолгүй”, “Төрд үрээ нэмэх, түмэнд төлөөн нэмэх”, “Төрд хууль бий, түмэнд ёс бий”, “Төрийг засах ухаан, иргэнийг жолоодох эрдэм”, “Төрийн дор захирагдаж, тэнгэрийн дор амьдрах”, “Төрийн ёс төв бол, түмэн хүний бишрэл, төрийн нуруу түвшин бол, түмний сэтгэл амгалан”, “Төрийн хүний төв нь сайн, төмөр хуурын дуу нь сайн”, “Төрийн хэргийг ганцаар бүү шийд, харин аянд ганцаар бүү морд”, “Төрөө гэвэл түмнээ түш, түмнээ гэвэл олноо хайрла”, “Ноён урваач, нохой шарваач”, “Ардын эрх улсын амь, улсын эрх ардын амь”, “Олны хүч, оломгүй далай”, “Дайсан ирэхэд тэмцэл хэрэгтэй, тайван суухад эв хэрэгтэй”, “Тэгш эрх байвал түвшин нөхөрлөл байна” гэх мэтээр улс төрийн сэтгэлгээний баялаг уламжлалтай ард түмэн юм.

Монголын улс төрийн сэтгэлгээний түүх агуулга ихтэй. Түүнийг авч үзэхэд нэгдүгээрт, Монголын улс төрийн сэтгэлгээний түүх нь агуулгаараа өргөн хүрээ багтаамж ба улс төрийн философи, улс төрийн сургаал, онол, номлол, үзэл суртал, улс төрийн үзэл санааны хэлбэр түвшинд илрэн гарч, оршин хөгжиж ирсэн болох нь тодорхой болж байна. Хоёрдугаарт, Монголын улс төрийн сэтгэлгээний түүхэнд төрийн тухай асуудал хэдийгээр гол болж тавигдаж ирсэн ч гэсэн нийгмийн амьдралын улс төрийн хүрээний бусад олон чухал үзэгдлүүд, тухайлбал, улс төрийн бодлого, засаглал, төр улсын тусгаар тогтнол, бүрэн бүтэн байдал, үндэсний эв нэгдэл, төр улсын задрал бутрал, түүнийг даван туулах асуудал, дарангуйлал, боолчлол, дайн ба энх, хууль цааз шударга ёс, тэгш байдлын тухай асуудлууд ч түүхэн тодорхой байдлаар тавигдаж байжээ. Түүхэн явцад Монголын улс төрийн сэтгэлгээний агуулга, түүнд хамрагдах асуудлын цар хүрээ ялангуяа ХХ зуунд өргөжин баяжиж, дээр дурдсан уламжлалт асуудлын зэрэгцээ нийгэм ба төрийн харилцаа холбоо, төр, засаглалын хэлбэр, зохион байгуулалт, үндсэн хуульт ёс, ард олны эрх, эрх

чөлөө, ардчилал, шударга ёс, сайн сайхан нийгэм байгуулах, хувьсгал, улс төрийн нам, олон нийтийн байгууллагын тухай зэрэг шинэ асуудлууд чухлаар тавигдсан байна.

IV. ДҮГНЭЛТ

Монголын нийгэм улс төрийн амьдрал түүхэн явцад хөгжиж, улс төрийн шинэ үзэгдлүүд гарч ирсэнтэй, нөгөөтэйгүүр улс төрийн сэтгэлгээ өөрөө бие даан өөрийн дотоод логик, хэрэгцээ шаардлагаар хөгжих болсонтой холбоотой юм.

Монголын улс төрийн сэтгэлгээний түүх бол тухайн түүхэн нөхцөлд үүсэн боловсрогдож, нийгэм, улс төр, оюун санааны амьдралд үүргээ гүйцэтгэн, цаг үе ба амьдралын өөрчлөлтийн эрхшээлээр түүх болж ардаа үлдсэн улс төрийн мэдлэгийн өв сан юм. Түүнийг зөвхөн оюун ухаанаар сэргээн санаж, судлан эзэмшиж болно. Улс төрийн сэтгэлгээний түүхийг судлан боловсруулахдаа шинжлэх ухааны судалгаа, танин мэдэхүйн зарчим, арга зүй, аргуудыг зөв зүйтэй хэрэглэх шаардлагатай болно.

НОМЗҮЙ

1. Алтан товч. (Лувсанданзан). УБ., 1990 он
2. Батсуурь Ж. Монголчуудын өлгий нутаг, гарал үүслийг генетикийн судалгаагаар мөшгөсөн нь, Дорно дахины судлалын асуудал. УБ., 1988 он, №1.
3. Жамбал А. Улс төрийн сургаалийн түүх. (Эртний үе) I-дэвтэр. УБ. 2001 он
4. Инжиннаши В. Хөх судар, УБ., 2006 он
5. Лүндэндорж Н. Төр, эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага. УБ. 2003 он.
6. Монголын нууц товчоо. УБ., 1990 он
7. Монголын философийн түүх. I дэвтэр. УБ. 1997 он
8. Монголын төр ёс, эрх зүйн сэтгэлгээний зарим асуудал. Хянан тохиолдуулсан профессор, доктор Н.Лүндэндорж. УБ. 2002 он
9. Сүхбаатар Г. Монголын түүхийн дээж бичиг. Тэргүүн дэвтэр. УБ. 1992 он
10. Цэрэнсодном Д. Монголын нууц товчооны эрдэм шинжилгээний орчуулга, тайлбар. Ред. Д.Төмөртогтоо. УБ., 2000 он